



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2022 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно.

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус нийт 15 хурал зарлагдснаас хараат бус гишүүний хувьд бүх хуралд 100% ирцтэйгээр дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон байна. Үүнд:

- “Хүний нөөцийн бодлого”- д хавсралтаар нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн,
- Банкны 2021 оны жилийн эцсийн Хөндлөнгийн Аудитлагдсан санхүүгийн тайлантай танилцаж, тайланг Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хуралд холбогдох дүгнэлтийг танилцуулж батлуулахаар шийдвэрлэв.
- 2021 оны жилийн эцсийн Аудитлагдсан санхүүгийн тайлан танилцуулсан,
- Зээлийн хороодын түвшин, эрхийн хэмжээ, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөлт оруулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосон, тухайлбал: 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөг буюу түүнтэй тэнцэх гадаад валют болон түүнээс доош дүнтэй зээлийн хүсэлтийг бие даан шийдвэрлэх эрх бүхий зээлийн хороодын түвшин, эрхийн хэмжээ, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөлт оруулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосон,

- Зарим зээлдэгчдийн нэмэгдүүлсэн хүүг чөлөөлөх эрхийг Гүйцэтгэх захирал, Зээлийн Ерөнхий хороонд олгохоор шийдвэрлэсэн,
- Банкны Биржийн бус зах зээлд гаргах хаалттай бондын талаарх саналтай танилцаж, холбогдох хууль журмын дагуу бондын судалгааг хийж эргэн танилцуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон,
- Гүйцэтгэх удирдлагын 2022 оны 01 дүгээр улирлын ажлын гүйцэтгэлийн тайлантай танилцаж, цаашид төлөвлөгөөний хэрэгжилтийг ахиулж ажиллахыг үүрэг болгосон,
- Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулж, ТУЗ-ийн 2021 оны ажлын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх тухай, ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах асуудлуудыг хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн,
- Банкны 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 сарын 25-ны өдөр банкны 2021 оны хөндлөнгийн Аудитын санхүүгийн тайланг батлах тухай, ТУЗ-ийн хараат бус гишүүний гэрээ контрактыг сунгах тухай асуудлыг хэлэлцүүлэн зарлахаар шийдвэрсэн,
- ТУЗ-ийн ажлын албаны дарга Ч.Баярмааг Гүйцэтгэх удирдлагын багт шилжин ажиллах болсонтой холбоотой 2022 оны 04 сарын 24-ний өдрөөр чөлөөлөхөөр шийдвэрлэсэн,
- Банкны бүтэц, орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн,
- ДАГ-ын аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлаар ДАГ-ын аудитор Б.Пүрэвжавыг өөрийн гаргасан хүсэлтийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөр дуусгавар болгон чөлөөлөхөөр шийдвэрлэсэн,
- “Силвэрмэн” ХХК-д 500,000,000.0 төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг жилийн 18% хувийн хүүтэй, 18 сарын хугацаатайгаар олгохоор шийдвэрлэв
- “Товь металл” ХХК-д 1,440,000.0 ам.долларын эргэлтийн хөрөнгийн зээлийг жилийн 10.80% хувийн хүүтэй, 24 сарын хугацаатайгаар олгохоор шийдвэрлэсэн,
- Банкны Гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбаярын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг шийдвэрлэж үүрэгт ажлаас нь чөлөөлөв
- Банкны Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Чулуунбаатар овогтой Баярмаа /РД: ХЖ88010701/-г 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс шинээр Гүйцэтгэх захирал томилогдох хүртэлх хугацаанд томилсон,
- Түвшинжаргал овогтой Түмэнжаргалыг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс Дотоод аудитын газрын ерөнхий аудитын албаны аудитор албан тушаалд томилов,

- Давааням овогтой Баялагмааг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс Дотоод аудитын газрын мэдээллийн технологийн аудитын албаны ахлах аудитор албан тушаалд томилов
- “Мотор сервис” ХХК-д 2,444,776,994 /Хоёр тэрбум дөрвөн зуун дөчин дөрвөн сая долоон зуун далан зургаан мянга есөн зуун ерэн дөрөв/ төгрөгийн эх үүсвэргүй гүйцэтгэлийн баталгааг эрсдэлийн 5% хувийн шимтгэлтэй, ажил гүйцэтгэсэн мэдэгдэл гарснаас хойш 28 хоногийн хугацаатайгаар олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбаяр/-д зөвшөөрөв
- “Мотор сервис” ХХК-д 2,602,158,345 /Хоёр тэрбум зургаан зуун хоёр сая нэг зуун тавин найман мянга гурван зуун дөчин тав/ төгрөгийн эх үүсвэргүй гүйцэтгэлийн баталгааг эрсдэлийн шимтгэл 5% хувийн, ажил гүйцэтгэсэн мэдэгдэл гарснаас хойш 28 хоногийн хугацаатайгаар олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбаяр/-д зөвшөөрөв
- Зөвшөөрөл олгох тухай “Ханбогд Кашимер” ХХК-д 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөгийн ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн зээлийг жилийн 3% хувийн, хүүгийн дэмжлэг /жилийн/ 10.65% хувийн хүүтэй, 24 сарын хугацаатайгаар олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбаяр/-д зөвшөөрөв
- Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр банкны нэр дээрх автомашин худалдан борлуулах талаарх асуудлыг хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулахаар хурлыг тус банкны 15 давхарын хурлын танхимд товлон
- Тээвэр хөгжлийн банкны “Хувийн банкны харилцагчийн бодлого”-ыг энэхүү тогтоолын хавсралт №1-ийн дагуу батлав
- Тээвэр хөгжлийн банкны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Т/22-06-01 дугаартай тогтоолоор батлагдсан “Тогтворжуулах төлөвлөгөө”-нд нэмэлт өөрчлөлт оруулан тогтоолын хавсралт №1-ийн дагуу шинэчлэн батлав
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн хараат гишүүдийг сонгон шалгаруулах түр хороо байгуулах тухай асуудлыг хэлэлцүүлэхээр тус хурлыг 2022 оны 06 дугаар сарын 27-нд зарлан товллохоор шийдвэрлэв.

2. Аудитын хороонд ажилласан тухай:

Аудитийн хороо нь 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд 1 удаа хуралдсан бөгөөд Аудитийн хорооны даргын хувьд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцож зөвлөмжийг хүргүүлсэн болно. Үүнд:

- 2022.05.27-ны өдрийн байдлаар хугацаа дууссан ч биелээгүй 24 зөвлөмжийг 2022.07.31-ний өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж дуусгах,
- ДАГ-ын зөвлөмжийг заасан хугацаанд хэрэгжүүлэхийг газар, нэгжийн захирлуудад, хяналт тавьж ажиллахыг хариуцсан орлогч, дэд захирлуудад албан байдлаар үүрэг болгох,
- ДАГ-ын зөвлөмжийг шалтгаангүйгээр удаа дараа хэрэгжүүлэхгүй, биелэлт, тайлбар ирүүлэхгүй байгаа нэгжийн удирдлага, ажилтнуудад шат дараалсан арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах,
- Ажлын гүйцэтгэлийг дүгнэх журамд ДАГ-ын зөвлөмжийн биелэлтийн байдлыг оруулан дүгнэх,
- ДАГ-ын бүтэц зохион байгуулалтад орсон өөрчлөлт болон газрын үйл ажиллагааны зарим процесс, дарааллыг сайжруулах, одоо хийгдэж байгаа дараалалд нийцүүлэх байдлаар ДАГ-ын үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулж баталсан.

3. Эрсдэлийн удирдлагын хороонд ажилласан тухай:

Эрсдэлийн удирдлагын хороо нь 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж, тус хурлаар Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлыг хэлэлцэж холбогдох журамд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Мөн түүнчлэн 2022 оны эхний 4 сарын байдлаарх банкны Эрсдэлийн нэгдсэн тайлантай танилцаж холбогдох мэдээллийг авч санал дүгнэлт өгч ажилласан болно.

Тайлан бичсэн:

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Б.Оюунцацрал